



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/251

Улаанбаатар хот

Амьжиргааны зардал олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Куба Улсын Засгийн газар хоорондын "Дээд боловсролын баримт бичиг, эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай" хэлэлцээр, Засгийн газрын 2026 оны "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 94 дүгээр тогтоол, Гадаад харилцааны яамнаас 2022 онд баталсан "Бүгд Найрамдах Аргентин Улс, Бүгд Найрамдах Куба Улстай хийсэн Гадаад харилцааны яамд хоорондын зөвлөлдөх уулзалтуудын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", Монгол Улсын Боловсролын сайдын 2025 оны "Амьжиргааны зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" А/440 дугаар тушаал, Бүгд Найрамдах Куба Улсын Элчин сайдын яамны 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн Rs. 72/2026 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Бүгд Найрамдах Куба Улсын дээд боловсролын байгууллагад 2026-2027 оны хичээлийн жилээс эхлэн суралцах хавсралтад нэр дурдсан иргэдэд амьжиргааны зардлыг Боловсролын зээлийн сангаас олгосугай.

2. Суралцагчийн амьжиргааны зардалд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Боловсролын эдийн засаг, санхүүгийн бодлогын газар /А.Мөнх-Оргил/-т, хэрэгжилтийг хангаж, суралцагчидтай гэрээ байгуулан, амьжиргааны зардлыг олгохыг Боловсролын зээлийн сан /П.Зохихсүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцааны газар /Б.Энхбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

1426010076

Боловсролын сайдын 2026 оны
08 дугаар сарын 14 өдрийн
А/251 дугаар тушаалын хавсралт

БҮГД НАЙРАМДАХ КУБА УЛС УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭТГЭЛГЭЭР 2026-2027
ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛЭЭС ЭХЛЭН СУРАЛЦАХ ОЮУТНЫ НЭРС

№	Овог	Нэр	Мэргэжил
1	Гансүх	Нандин	Тусгай хэрэгцээт хүүхдийн багш
2	Хатантөмөр	Бат-Ялалт	Эмч
3	Амарсанаа	Мөнх-Очир	Эмч
4	Мягмаржав	Хишигдэлгэр	Эмч
5	Мөнхдорж	Энххатан	Эмч
6	Нургуль	Дилан	Эмч

--o0o--